

Article

Exploring the Integration of SDG 4 “Quality Education” in English Language TeachingOdon Dashnyam^{1*}¹ Department of General Education, Shihihutug university, Ulaanbaatar, Mongolia*Corresponding author: odon@shihihutug.edu.mn <https://orcid.org/0009-0009-2852-9831>

Received: 01 November 2025**Accepted: 12 December 2025****Published online: 31 December 2025**

Abstract

The United Nations’ Sustainable Development Goals provide a global framework for addressing urgent environmental, social, and economic challenges. Education for Sustainable Development within SDG 4, Quality Education, highlights education’s role in shaping responsible global citizens. This paper explores how English Language Teaching can integrate SDGs to enhance language proficiency while strengthening critical thinking, intercultural competence, and sustainability awareness. Through content-based and task-based approaches, learners engage with real-world issues. The study presents strategies, classroom examples, and challenges, advocating relevant English education.

Keywords: English Language Teaching, Education for Sustainable Development, Global Citizenship Critical Thinking, Language Education, Curriculum Integration



© 2025, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator.

<https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Тогтвортой хөгжлийн зорилтын 4 дүгээр зорилтыг англи хэлний сургалтад нэгтгэх боломж, арга зам

Дашнямын Одон¹

¹Шихихутуг их сургууль, Ерөнхий Эрдмийн тэнхим, Улаанбаатар хот, Монгол улс

Хураангуй

Нэгдсэн Үндэстний Байгууллагын - НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх дэлхийн цар хүрээг бүрдүүлдэг. Үүн дотроо Чанартай боловсрол олгох 4 дүгээр зорилтын хүрээнд Тогтвортой Хөгжлийн Боловсрол нь хариуцлагатай дэлхийн иргэдийг төлөвшүүлэхэд боловсролын үүргийг онцолж өгдөг. Энэхүү өгүүлэлд оюутны шүүмжлэлт сэтгэлгээ, харилцаа, соёл хоорондын ойлголт зэрэг хэлний мэдлэг ур чадварыг сайжруулахын зэрэгцээ Тогтвортой Хөгжлийн Зорилтууд бүхий агуулгыг хэлний хичээлд багтаан зааж болохыг судалсан. Ингэснээр хэлний хичээлийн агуулгад суурилсан, даалгаварт суурилсан зэрэг арга барилуудаар дамжуулан суралцагчид дэлхий дахинд тулгарч буй асуудлуудыг танин мэдэж, түүнийг шийдвэрлэх зэрэг чадвар эзэмшдэг. Бид энэхүү судалгаагаар англи хэлний чанартай боловсролыг олгоход шаардагдах стратеги, арга барил, тулгарах бэрхшээлүүдийг шийдвэрлэх арга замтай нь судлан таниулахыг зорилгоо.

Түлхүүр үгс: англи хэлний заах арга зүй, тогтвортой хөгжлийн боловсрол зорилго, шүүмжлэлт сэтгэлгээ, хэлний ур чадвар, дэлхийн иргэн, сургалтын хөтөлбөр

Удиртгал

Орчин үед боловсрол нь зөвхөн хэлний мэдлэгтэй төдийгүй нийгэм, байгаль орчны талаар ухамсартай, дэлхий иргэн-хувь хүнийг төлөвшүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. “Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод дэлхийн улс орнуудын төрийн тэргүүнүүд НҮБ-ын хурлаар “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл болгон 2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулганд ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

Тогтвортой хөгжлийн зорилтууд нь ядуурал, тэгш бус байдлаас эхлээд уур амьсгалын өөрчлөлт, энх тайван зэрэг бүх нийтийг хамарсан дэлхийд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх дэлхийн бүх улс, үндэстнийг хамарсан хэтийн хамтдаа хүрэх зорилго болсон. 2030 оны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт ТХЗ-ууд хүртээмжтэй, тэгш боловсролын ач холбогдлыг онцолж, Тогтвортой хөгжлийн боловсролыг (ТХБ) үндсэн нэгэн элемент болгон онцолсон байдаг.

Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) нь ялангуяа засгийн газрын ТХЗ-н хүрээнд “ногоон боловсрол” хэмээх агуулгын хүрээнд суралцагчдад тогтвортой хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйл, эерэг хандлага -ыг эзэмшүүлэхэд боловсролын тогтолцооны чиглэлийг өөрчлөхийг уриалсан, улс орнуудын нэгдмэл нэг зорилтын дор жагссан алсын зорилго юм. Дэлхийн боловсролын гол бүрэлдэхүүн хэсгийн нэг болох Англи хэлний сургалт (ELT) нь дэмжих чадвар /аюулгүй байдал/ эрүүл энх зэрэг -sustainable гэх үндсэн нэр томъёонд багтах тогтвортой хөгжлийг дэмжих нэгэн

платформ болох боломжтой. Тогтвортой Хөгжлийн боловсрол түүн дотроо “Чанартай Боловсролыг Дэмжих “-ТХЗ- Зорилт 4 хангахын тулд шийдвэрлэх шат дараалласан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд: Боловсролын бодлого, *агуулгад сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, хариуцлагатай хэрэглээ, хүйсийн тэгш байдал зэрэг сэдвийг багтаах*, үндэсний хэмжээнд боловсролын стратеги, бодлогын бичиг баримтад ТХБ-ыг тусгах зэргээр ТХБ-ыг тусгах, *багш, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах*, сургалтаар тогтвортой хөгжилтэй холбоотой мэдлэг, арга зүй олгох, *сургуулийн тогтвортой хөгжлийн систем нэвтрүүлэх*, “Ногоон сургууль” санаачилгын хүрээнд хог хаягдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, *байгальд ээлтэй дадал хэвшүүлэх, орон нутгийн хамтын оролцоог дэмжин, сургуулийн гадаад орчинд тогтвортой байдлыг сурталчилах*” зэргээр ТХЗ-г дэмжсэн тогтвортой хөгжлийн боловсролд хувь нэмэр оруулах олон арга зам байна.

Мөн гадаад хэлний багш нар чанартай боловсрол олгохын тулд эдгээр зорилтуудыг хичээлийн хөтөлбөрт нэгтгэж болохыг судалж, оюутан хэлний ур чадвар төдийгүй дэлхийн мэдлэгийг олгох ач холбогдолтой. Үүгээр дамжуулан оюутнуудын *хэлний мэдлэгээс гадна шүүмжлэлт сэтгэлгээ, бусдыг өрөвдөх энэрэх сэтгэлтэй, дэлхийн хариуцлага мэдрэмж /critical thinking, empathy, and a sense of global responsibility/* -ийг нэгэн зэрэг хөгжүүлэх боломжтой. Хэлний сургалтын олон арга барилын хэсэг болох “агуулгад суурилсан зааварчилгаа”, “төсөлд суурилсан сургалт”, “*жинхэнэ эх үүсвэр бүхий текст ашиглах*” зэрэг практик стратегиар дамжуулан багш нар хэлний хичээл сургалтаа бодит ертөнцийн асуудлыг судлах орон зай болгон хувиргаж чадна. Энэхүү интеграцчилал нь ТХБ-ын зорилгод нийцэх төдийгүй оюутнуудыг илүү тогтвортой хөгжлийн *идэвхитэй, мэдээлэл бүхий дэлхийн иргэн, оролцогч* болоход бэлтгэн гаргах зорилготой.

Судалгааны ажлын зорилго

Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих хэргэжүүлэх үүднээс англи хэлний сургалтанд нэгтгэх онол-арга зүйн үндэс, практик боломж, үр нөлөөг судлан тодорхойлж, хэлний боловсролоор дамжуулан дэлхийн хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх боломжийг үнэлэхэд судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын зорилтууд

- Тогтвортой хөгжлийн боловсрол дэмжих сэдэвт хэлний хичээлд сургалтын ямар арга технологи хэрэглэж болохыг судлах.
- Англи хэлний хичээлд хэрэгжүүлэх боломжтой сургалтын үйл ажиллагааны жишээг тодорхойлох
- ТХЗ-ыг англи хэлний сургалтад нэгтгэхэд тулгарч буй бэрхшээл, сорилтуудыг тодорхойлж, тэдгээрийг даван туулах санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны ажлын шинэлэг тал

- Англи хэлний сургалтыг зөвхөн хэлний чадвар хөгжүүлэх бус, дэлхийн чин хандлагад нийцүүлэх үүднээс Тогтвортой хөгжлийн боловсролыг хэрэгжүүлэх бодит орон зай гэж үзэн онол-практик бүхий хандлага дэвшүүлсэн.
- Англи хэлний сургалтын бодит кейс, ЕАР хөтөлбөрийн жишээнд тулгуурлан ТХЗ-ын интеграцийн практик загварыг тодорхойлж гаргалаа.
- ТХЗ-ыг хэлний 4 чадвар (унших, бичих, сонсох, ярих)-тай уялдуулан ур чадвар + тогтвортой сэтгэлгээ хосолсон сургалтын боломжийг харуулсан.

Судлагдсан байдал

Тогтвортой хөгжлийн боловсрол болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг боловсролын салбарт, ялангуяа гадаад хэлний сургалттай уялдуулах асуудал нь сүүлийн арван жилд олон улсын практикт болон судалгаанд өргөнөөр хөндөгдөж байна. ТХЗ-ын 4 дүгээр зорилт болох “Чанартай боловсрол” нь бүх зорилтуудын хэрэгжилтийг дэмжих суурь нөхцөл хэмээн судлаачид онцолдог. Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО 2017 онд Тогтвортой хөгжлийн зорилт 4 нь суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээ, тэгш хүртээмж, насан туршийн суралцах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого хэмээн тодорхойлсон. Barber (2023) болон Peachey (2018) нарын судалгаанд ТХЗ 4-ийн хүрээнд англи хэлний хичээлд төсөлд суурилсан сургалт, агуулгад суурилсан сургалт, бодит эх үүсвэр ашиглах нь хэлний чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ боловсролын чанар, суралцагчийн оролцоог нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ.

Монгол Улсад Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих бодлогын хэрэгжүүлэх талаас 2018 оны “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөр, ЮНЕСКО-ийн “Ногоон боловсролын хамтын ажиллагаа” зэрэгт хөндөгдсөн боловч англи хэлний сургалтад ТХЗ-ыг системтэйгээр нэгтгэсэн судалгаа харьцангуй хомс байдаг. Иймээс энэхүү судалгаа нь англи хэлний сургалтын бодит туршлагад тулгуурлан ТХЗ-4 -ийг сургалтанд хэрэгжүүлэх боломжийг судалж буйгаараа судалгааны хийдэл орон зайг нөхөж байгаагаараа онцлогтой.

Судалгааны арга зүй:

Энэхүү судалгаанд хэл шинжлэл, нийгэм-соёлын уялдаа холбоог харуулахыг зорьсон практикт суурилсан тоон болон чанарын, ажиглалтын судалгааны арга ашигласан болно. Ингэхдээ сургалтын арга барил болон хичээл дэх үйл ажиллагааны жишээг тайлбарлан дүгнэх, ажиглах, туршилт, асуулга зэрэг эмпирик арга зүйг мөн ашигласан.

I. Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон Тогтвортой Хөгжлийн Боловсролын зарчмуудын тойм ойлголт

2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулганаас үүдэлтэй, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилт батлагдан, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. ТХЗ -ийн хамрах хүрээнд, “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь *нийгэм, эдийн засаг, байгаль орчин* гэсэн гурван тулгуурт зорилтод суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг болсон. Улс орнууд үүнд өөр өөрийн хувь нэмрээ оруулах, ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад “Бүс нутгуудын засгийн газрууд, яамд, төрийн ба төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд, их дээд сургуулиуд, орон нутгийн байгууллагууд зэрэг холбогдох бусад байгууллагууд болон иргэд оролцоно” хэмээн төлөвлөн ажиллаж байна. Тэр дундаа боловсролын байгууллагуудын хувьд тогтвортой хөгжлийн боловсрол - ТХБ нь томоохон байр суурь эзлэх ба ЮНЕСКО нь бүх түвшинд тогтвортой хөгжлийн *боловсролын хүртээмжийг сайжруулах, боловсролыг шинэчлэн хүмүүсийн мэдлэг, ур чадвар, үнэ цэнэ, зан төлөвийн байдалд эерэг хандлагад* хувирган хөгжүүлэх зорилготой юм. Энэ нь тогтвортой хөгжилд тулгамдаж буй нийтлэг асуудлууд болох *дэлхийн дулаарал, боловсролын хүртээмжгүй байдал, тэгш бус байдал* зэрэг дэлхийн томоохон сорилтуудыг шийдвэрлэх тал дээр боловсролын агуулгад тусгах юм.

Боловсрол дахь тогтвортой хөгжлийн зорилтын хүрээн хийгдэж буй ажлууд:

Тогтвортой хөгжлийн боловсролд, ТХЗ -ын №4 болох Чанартай Боловсрол олгох нь нэг бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд тогтвортой хөгжлийг дэмжих гол хүчин зүйл хэмээн олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдөөд байна. ЮНЕСКО нь ТХБ-ыг дэмжих үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг зохицуулах үүрэг хүлээдэгийн хувьд *дэлхий нийтээрээ 2030 он*

хүртэл хэрэгжүүлэх зорилтуудад *тогтвортой хөгжлийн боловсролыг* багтаасан байдаг. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын дагуу 2018 оноос “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Бүх нийтэд *байгаль орчноо хамгаалах, түүх, соёлын өвийг дээдлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох, гамигийн эрсдэлийг даван туулах, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх* зэрэгт чиглэсэн тогтвортой хөгжлийн олон зорилтууд тусгасан агуулга бүхий боловсролыг эзэмшүүлж, Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад хөтөлбөрийн зорилго оршино. Монгол Улс түүнчлэн ЮНЕСКО-ийн Ногоон боловсролын хамтын ажиллагаа (Greening Education Partnership)-ны гишүүн юм. Тус хамтын ажиллагаа нь 2023-2024 онуудад "Ногоон боловсролын хичээлийн хөтөлбөр" болон "Ногоон сургуулийн чанарын стандарт" гэх томоохон бодлогын зөвлөмж боловсруулсан байна.

Англи хэлний боловсролыг Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд ашиглан Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих нь улс орнуудад хэрэгжиж буй үр дүнтэй аргын нэг юм. Дэлхийн хэмжээнд улс орнууд хэрхэн боловсролоор дамжуулан ялангуяа англи хэлний сургалтаар дамжуулан Тогтвортой Хөгжлийн Боловсролыг хэрэгжүүлж буй зарим орны арга туршлагыг дурдвал:

Филиппиний нэгэн их сургуулийн лаборатори сургуульд нэгэн багш англи хэл болон уран зохиолын хичээлд ТХЗ-ын талаар заан туршилт хийжээ. Энэхүү судалгаагаар сурагчид дэлхийн асуудлуудын талаар мэдлэгтэй болж, асуудлыг шийдвэрлэх чадвар, шүүмжлэлт сэтгэлгээ, хамтын ажиллагааны ур чадвараа хөгжүүлсэн байна. Судалгааны загвар ба аргачлалын хүрээнд “Үзэгдэл судлалын хандлага-Phenomenological Approach” англи хэлний хичээл дэх ТХЗ-ын сурагчдын амьдралын туршлагыг судлах зорилгоор дүрслэх чанарын аргыг ашиглажээ. Тухайн сургуулийн сурагчтай ярилцлага болон фокус бүлгийн ярилцлага мэдээлэл цуглуулах зэргээр зорилттой холбоотой сэдвүүдийг бодит амьдрал дээр хөндөн асуудлыг шийдвэрлэх чадварыг нь хөгжүүлж, англи хэл, уран зохиолын агуулгыг дэлхийн асуудлуудтай холбож, оролцооны хандлагыг төлөвшүүлэн оюутнуудын идэвхитэй оролцоог дэмжиж, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд суралцагчдыг санаачлагатай байхыг урамшуулах зэргээр хичээлдээ хэрэгжүүлжээ. Үр дүнд нь оюутнууд ангийн болон ангиас гадуурх дэлхийн асуудлаар арга хэмжээ авах хүсэл эрмэлзэл нэмэгдэж, мөн хичээлийг илүү сонирхолтой, хамааралтай болгож, академик агуулгыг оюутнуудын амьдрал, нийгэмтэй холбосноор тухайн сургуулийн ТХ зорилгод хандах арга барил өөрчлөгдөн, боловсролын иймэрхүү цогц арга барилын ач холбогдлыг онцолж, сургалтын агуулгад ТХЗ-ын сэдвүүдийг оруулахыг дэмжсэн Филиппин улсын туршлага байна.

Cordova. M (2024) онд “Integrating sustainable development goals in English language and literature teaching” буюу Англи хэл, уран зохиолын сургалтад тогтвортой хөгжлийн зорилтуудыг нэгтгэх нь” судалгаандаа Их Британид англи хэлний багш нар хичээлдээ энэхүү зорилтын арга зүй боловсруулсан туршлагын талаар Даниел Барберын "The SDGs and English Teaching" хэмээх бүтээлдээ НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг англи хэлний сургалтад нэгтгэх практик аргуудыг тодорхойлсон. Эдгээр аргууд нь сурагчдын дунд дэлхийн мэдлэг, шүүмжлэлтэй сэтгэлгээг төлөвшүүлэхийн зэрэгцээ хэлний сургалтыг сайжруулах зорилготой байсан. ”Дэлхийн асуудлаар бүлгийн хэлэлцүүлэг” явуулснаар оюутнууд дэлхийн томоохон сорилтуудыг тодорхойлж, хэлэлцэн бүлгээр хамтран ажилласан, “ТХЗ-ыг танилцуулга” ажлын хүрээнд багш нар зорилго тус бүрийн зорилтуудыг сурагчдад таниулах

зорилгоор ТХЗ-уудын зурагт хуудас, үзүүлэн таниулах хэрэглүүр ашиглан ТХЗ-ыг танилцуулсны дараа оюутнууд онлайн материал, эх үүсвэр нөөцийг ашиглан судалгаа хийснээр тэд судалгааны болон илтгэх чадвараа англи хэл дээр сайжруулж, олж мэдсэн зүйлээ ангид танилцуулах чадвар эзэмшсэн, мөн түүнчлэн “Role Play”, “Class voting on SDG Priorities”, “Project-Based Learning” зэрэг арга барил ашиглан ятгах зэрэг хэлний ур чадварыг хөгжүүлснээр оюутнуудад хэлний мэдлэгээ бодит нөхцөл байдалд ашиглах боломжийг олгон олон талт ажиллагааг хэрэгжүүлж сурч болохыг судалгаагаараа батлан харуулсан. Barber, (2023)

Харилцаа холбоо, эдийн засаг, нийгмийн хэл болох англи хэлний үүрэг:

Англи хэл нь харилцаа холбоо, нийгэм, эдийн засгийн хамгийн өргөн хэрэглэгддэг хэлний хувьд эдгээр дэлхий дахинаа түгээмэл нийтлэг сэдвүүдийг судлах үндсэн хэрэгсэл буюу "лингва франка" болж, дэлхийн асуудлуудыг шийдвэрлэх болон олон улсын яриа хэлэлцээнд нэвтрэх боломжийг олгодог гэж үздэг. Иймээс Тогтвортой хөгжлийн зорилтуудыг боловсролын салбарт хэрэгжүүлэхэд сургалтанд шинэлэг арга, аргачлал ашиглах хэрэгтэй байна.

Тогтвортой хөгжлийн зорилгууд нь 2030 он хүртэл хэрэгжүүлэх алсын хараатайн хувьд дэлхий нийтээрээ түүнд хүрэх, зорилтын нэг болох ТХЗ 4 буюу "Чанартай боловсрол"-ыг бүх хүнд хүртээмжтэй болгох зорилтын хүрээнд хэлний боловсролын олон талт агуу====лгыг шинэчлэн, тогтвортой хөгжлийг дэмжих шаардлага гарч байна. Тогтвортой хөгжлийн боловсрол нь сурагчдад нийгэм, хүмүүнлэг, хүрээлэн буй орчны талаар мэдлэг олгохоос гадна тэдэнд *нийгмийн шударга ёс, эдийн засгийн тогтвортой байдал, ирээдүйн төлөөх хариуцлагатай иргэн байх, зөв шийдвэр гаргах* зэрэг чадваруудыг эзэмшүүлэхийг зорьдог.

Хэлний боловсрол нь дэлхийн иргэншил, соёл хоорондын харилцан ойлголцлын хэрэгсэл гэж Вугам М, (2008) үзсэн. Хэл болон боловсролын олон талт агуулга, арга барилуудын нэгээхэн хэсэг болох Агуулга болон хэлний нэгдсэн сургалт-Content and Language Integrated Learning (CLIL) болон даалгаварт суурилсан сургалт -Task-Based Learning (TBL) нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлууд гэх мэт сэдэвт агуулгыг хэлний сургалтанд оруулах үр дүнтэй тогтолцоо гэж үзэх нь байдаг (Coyle, Hood, & Marsh, 2010). Бодит ертөнцийн талаарх сэдэв бүхий агуулга судлах, эзэмших нь суралцагчийн урам зоригийг нэмэгдүүлж, хэл ярианы чадвар хөгжихөөс гадна дэлхийн хэмжээний мэдлэг эзэмшихэд хүргэдэг гэж судлаачид дүгнэсэн байдаг.

Dörnyei, Z. and Ushioda, E (2009) нарын эрдэмтдийн хийсэн судалгаагаар хичээлийн агуулгад дэлхийн жинхэнэ сорилтуудыг тусгах үед суралцагчдын илүү *дотоод хүсэл эрмэлзэл, сэдэл, хэл ярианы үр дүн* сайжирдаг болохыг харуулсан байдаг. Дээрх судлаач нар хоёрдогч хэл (L2) эзэмших заах арга зүйн салбарт нэр хүндтэй эрдэмтэд бөгөөд “Сэдэл түүний онцлог, хэлний харилцаанд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг” гэж үзсэн. Мөн ТХЗ-ыг хичээл сургалтанд ашиглаж, оруулах нь багш нарт өөрчлөлтийн төлөөлөгчөөр ажиллах боломж ба салбар хоорондын холбоосыг бий болгох боломжтой” гэж үзсэн байдаг. Leicht, J (2018)

II. Сургалтын олон арга барил нь заах арга зүйн үндэс болох нь:

Хэлний сургалтанд Агуулгад суурилсан сургалт (Content-Based Instruction, CBI), Төсөлд суурилсан сургалт (Project-Based Learning, PBL), Харилцан ярианд суурилсан хэлний сургалт (Communicative Language Teaching) нь түгээмэл хэрэглэгддэг. Мөн Шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд педагогик- сурган хүмүүжүүлэх арга зүй хэрэглэгддэгийн хувьд хэлний үндсэн *бичих, унших, ярих, сонсох* - чадваруудыг хөгжүүлэхэд дээрх арга барилуудаас хичээл сургалтанд нэвтрүүлэх нь боловсролыг үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэхэд чухал байр

суурь эзэлдэг. Сургалтанд олон талт практик арга барилыг хэрэгжүүлснээр хэлний сургалт нь *нийгэм, эдийн засаг, дэлхийн мэдлэг* бүхий мөн үүрэг хариуцлагаа ухамсарласан *дэлхийн иргэн* бий болгоход хэлний боловсрол нэн чухал үүрэгтэй.


Энэ нь Англи хэл заах арга зүй болон ТХЗ-ийг хэрэгжүүлэхэд хэлний олон талт арга барил дээр хэрэгжих боломжтой ба хэл эзэмшүүлэхэд дээрх арга барилууд нь сургалтын сайн хослол болдог. Шихихутуг их сургууль нь хэлний түгээмэл мэдлэг чадвар бүхий дэлхийн иргэн, хуульч бэлтгэн улс орны төдийгүй дэлхий түвшинд гаргах алсын хараа зорилгынхоо хүрээнд 2018 оноос хойш Оксфордын их сургуулийн Академик Англи хэлний (English for Academic Purpose -EAP) хөтөлбөрийг 8 дах жилдээ хэрэгжүүлж байна. Хэлний энэхүү хөтөлбөр нь бакалаврын сургалтын эхний хоёр жилийг багтаасан сургалт ба оюутнуудын хэлний суурь түвшний ялгаатай байдлаас үүдэн А1-А2, В1-В2, С1-С2 түвшнийг эзэмшүүлдэг ба, оюутнуудын англи хэлний академик чадварыг хөгжүүлэх зорилготой. Хэлээр дамжуулан олж эзэмших академик ур чадварын хэрэгцээ нь өнөөгийн нийгэмд төдийгүй ажлын байранд голлон шаардагддаг ур чадварууд бөгөөд бичгийн, ярианы зэрэг чадварууд болох */академик текст унших, эссээ бичих, судалгаа хийх, эзэмшсэн мэдлэгээ ур чадвартай илтгэх гаргах/* зэрэг нь амьдрал, практикт нэн чухал юм. Энэ хөтөлбөрөөр суралцагчид *унших, сонсох, ярих, бичих* даалгавруудаар дамжуулан бодит ертөнцийн өргөн хүрээний сэдвүүдийг судладаг. Сургалтын явцад хэрэгжүүлж, ашиглаж буй сурах бичиг, номонд *байгаль орчныг хамгаалах, жендэрийн тэгш байдал, сэтгэцийн эрүүл мэнд, боловсролын хүртээмж, тогтвортой хотууд* зэрэг Тогтвортой хөгжлийн хэд хэдэн зорилттой дүйцэх (SDGs 3,4,5,10-13 гэх мэт), нягт уялдаатай сэдвүүдийг агуулсан хичээл сурах бичгүүдэд нилээн байдаг. Ангийн олон үйл ажиллагаа, бие даасан даалгавар нь мэтгэлцээн, судалгааны эссэ, шүүмжлэлтэй эргэцүүлэн бодох, бүлгээр хэлэлцүүлэх, ярианы танилцуулга зэрэг нь *уламжлалт хичээлийн сэдэв арга технологийг* бодвол илүү дэвшилтэт арга барилуудыг шаарддаг бөгөөд оюутнуудыг орчин үеийн дэлхийн асуудлуудын талаар шүүмжлэлтэй сэтгэж, илүү өргөн цар хүрээтэй бодож сэтгэхэд уриалдаг ба оюутнууд өөрсдөө эдгээрт шийдэл гарган ажиллах боломж эзэмшдэгээрээ давуу талтай. Эдгээр аргыг хичээлд хэрэглэснээр тогтвортой хөгжлийн боловсролыг хэлний сургалтанд ашиглах гарцыг бий болгож байна. Манай их сургууль англи хэлний сургалтдаа Q Skills for Success, Oxford EAP зэрэг сургалтын номуудыг ашигладаг ба энэхүү сурах бичгүүд нь агуулгад суурилсан сэдвүүд бүхий шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх академик ур чадвар эзэмшүүлдэг цуврал сургалтын материалын нэг юм. Тухайн сургалтын номонд багтсан нэгж сэдвүүд нь ихэвчлэн орчин үеийн нийгмийн чухал сэдвүүдийг хөндсөн байдаг нь тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн байдагт, тухайлбал:

- Байгаль орчинтой холбоотой сэдэв (жишээ нь, нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах, цөлжилт, ногоон хот, технологи) ТХЗ 7,9,12,13- аар зорилтууд
- Нийгмийн шударга ёс (жишээ нь, жендэрийн үүрэг, тэгш бус байдал) ТХЗ 5,10,16
- Нийгмийн эрүүл мэнд, сайн сайхан байдал (жишээ нь, сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэг, цэвэр усны хүртээмж) ТХЗ 3,4,6

Хичээлийн зарим нэгж бүрэлдэхүүн хэсэгт суралцагчдыг шүүмжлэлтэй сэтгэж, нийгмийн асуудлын талаар үзэл бодлоо илэрхийлэхэд уриалсан эрдэм шинжилгээний бичвэрүүд, хэлэлцүүлэг, бичих зэрэг даалгаврууд багтдаг. Харин багш үүгээр дамжуулан тогтвортой хөгжлийн дэлхийн нийтийн чиг хандлагыг тайлбарлан таниулж, хичээл сургалтыг үүнтэй нийцүүлэн хөгжүүлэн хэрэгжүүлэх асуудалтай тулгардаг. Жишээлбэл, дэлхийн хэрэглээний үзэл баримтлалын нэг хэсэг нь шалтгаан-үр дагаврын бүтцийг заадаг төдийгүй

суралцагчдыг SDG 12 дугаар зорилтын хүрээнд хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлтэй нягт уялдуулан, тогтвортой худалдан авалтын дадал зуршлыг суулгах, нийгэмд үлгэр дууриал бусдад түгээх сэдвийн хүрээнд хичээлд судалгаа хийлгэх зэргээр авч хэрэгжүүлсэн.

ТХЗ -ын шийдэл бүхий *хот байгуулалт, байгаль орчин, ёс зүй* гэх мэт үндсэн сэдэвтэй дүйцэх аливаа даалгавар нь суралцагчдаас янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийг *нэгтгэх, дүгнэх, задлан шинжлэх, эх бэлтгэх, ярих, мэтгэлцээнд оролцох, эссэ бичих* зэрэг зэргээр академик ур чадвар сурангаа оюутнууд 21 дүгээр зууны шаардлагатай гэж үздэг мэдлэг ур чадварыг мөн эзэмшиж байдаг. ТХЗ-ын хотжилт, тэгш бус байдал, боловсролын системтэй холбоотой сэдвүүд нь нийгэм, байгаль, дэлхийд тулгарч буй асуудлуудыг бүтээлчээр шийдвэрлэх бас нэгэн 21-р зууны ур чадвар шаарддаг сэдэв болдог.



Зураг 1: XXI зууны боловсролд шаардлагатай чадамжууд ба Тогтвортой хөгжлийн боловсролын уялдаа

Хичээл сургалтанд ашиглагдаж буй манай сургалтын номон багтсан хичээлийн сэдвүүд нь түвшин бүрт харилцан адилгүй, сурах бичиг бүрт өөр өөр ур чадвар шаардсан сэдвүүд багтдаг ба тэдгээр нь уламжлалт англи хэл заах арга барилаас илүүтэй дэвшилтэт сэдэв, агуулга бүхий контент багтаасан байдаг нь өнөөгийн нийгэмд тулгарч буй олон асуудлыг хөндсөн, шийдвэрлэх арга замуудыг эрэлхийлэхийг оюутнууднаас шаардсан бүтэцтэй байдаг нь оюутнуудад *хөгжиж, суралцаж, ур чадвар эзэмшингээ дэлхийн иргэн байхын чухалыг* хэлний хичээлээр дамжуулан ойлгуулж ухамсарлуулдаг. Сургалт бүрт хэлний 4н чадамж шаардсан сэдэв, агуулга багтсан байх ба мөн ТХЗ-ын хэд хэдэн зорилтуудтай нийцэх дадал, даалгаварууд багтсан байдлыг харуулвал:

Хүснэгт 1: Англи хэлний хичээлийн ур чадвар ба Тогтвортой хөгжлийн зорилтуудын уялдаа

Language skill	SDG focus	Example Activity
Writing skill /focusing on not only essay structure but also learning real-world of challenges/	SDG 1 : Poverty	Write a cause-effect essay on poverty and inequality

Reading /perceiving a citizen’s responsibility, proposing practical solutions/	SDG 13: Climate action	Discuss ways to reduce plastic waste in daily life
Listening /exposure to authentic voices and perspectives/	SDG: 4 Education	Compare global education systems using academic texts
Speaking /understanding multiple viewpoints, collaboration/	SDG 3: Health	Watch interviews with youth activities on mental awareness

Эдгээр арга барилыг тогтмол хэрэгжүүлснээр хэлний хичээлийг академик хөгжилд хөтөлсөн, дэлхийн асуудлын талаарх ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэсэн орчин болгон өөрчилж чадна гэж бид үзэж байна. Багш нарын хувьд дээрх зорилтуудын хүрээнд хичээлд төрөл бүрийн арга барил ашиглангаа даалгаврыг суралцагчдын хэлний мэдлэгийн түвшинд тохируулан боловсруулснаар сурагчид англи хэл болон тогтвортой хөгжлийн сэдэвт сорилт бүхий даалгавар, гүйцэтгэлд идэвхи санаачлагатай оролцонгоо *дэлхийн мэдлэг, ур чадвар, ухамсарыг* өөртөө төлөвшүүлж сурна.

Хэлний боловсролд тэгвэл яагаад ТХЗ -уудыг нэгтгэх шаардлага үүссэн талаар асуудал өрнөж магадгүй юм. Нэгт боловсролыг дэлхийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн зэрэгцээ суралцагчдыг зөвхөн *хэлний хэрэглэгч бус дэлхийн хариуцлагатай иргэн* болоход дэмждэг гэдэг талаас нь харахад эдгээр зорилтыг сургалтанд хэрэглэх нь зүйтэй.

III. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаандаа чанарын, практик суурилсан судалгаа болон кейс судалгааны аргыг хослуулан хэрэглэлээ. Судалгаа нь тайлбарлан дүгнэх буюу *descriptive–integrative* шинжтэй бөгөөд сургалтын бодит кейс, туршлага, ажиглалтад тулгуурласан болно. Тогтвортой хөгжлийн зорилтууд буюу дэлхийн чиг хандлагыг түгээн таниулж хичээл сургалтанд нэвтрүүлж хэрэгжүүлэхийн тулд хэл сурах үйл явцтай уялдуулах, мэдлэгт суурилсан стратеги шаардлагатай. Иймээс тогтвортой хөгжлийн боловсролын зарчмуудыг англи хэлний хичээлд нэвтрүүлэх, ашиглаж болох хэд хэдэн үр дүнтэй аргуудыг тоймлон харуулав.

1. Сэдэвчилсэн агуулгын хэрэглэх буюу интеграцчлалын тойм-Content Based Learning - CBL

Хамгийн энгийн бөгөөд үр дүнтэй хичээлд хэрэгжүүлдэг аргын нэг бол ТХЗ- той холбоотой сэдвээр хичээлийг зохион байгуулах явдал юм. Сурах бичигт агуулагдсан сэдвийн хүрээнд *ур амьсгалын өөрчлөлт* ТХЗ -ын 13-р зорилго, *жендэрийн тэгш байдал* ТХЗ -5, *цэвэр ус ба ариун цэврийн байгууламж* ТХЗ-6 эсвэл *хариуцлагатай хэрэглээ* буюу ТХЗ-12 зорилго зэрэгтэй нийцэх контент агуулга бүхий сэдвүүдийг судласанаар нь *үгсийн сан, уншиж ойлгох чадвар, шүүмжлэлтэй ярилцах чадвар*-ыг хөгжүүлэхийн зэрэгцээ оюутнууд өнөөгийн дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудын талаар ухамсарлан ойлгож байдаг. Жишээ нь, оюутнууд *усны хомсдол, цөлжилт* зэргийн тухай нийтлэл уншнаар, сэдвийн хүрээнд хэлний мэдлэгээ дээшлүүлэх хэдий ч, ТХЗ зорилт бүхий хичээлийг судалж даалгавар гүйцэтгэснээр нийгмийн сорилтуудыг шийдвэрлэх боломжыг эзэмшин тухайн оюутан “дэлхийн иргэн” гэх ойлголтонд хүрэх алхам болдог.

Хичээлд хэрэглэгдсэн жишээнээс дурдвал: Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөний талаар сэдэв үзэхэд Оксфордын академик англи хэлний сурах бичиг 4т Байгалийн тухай хичээлд оюутнууд цөлжилтийн талаар нийтлэл уншиж, байгаль хамгаалах, ухаалаг хотуудын талаар судалгаа хийх, прэзентаци эссэ бичих зэрэг даалгавар гүйцэтгэсэн.

2. Төсөлд суурилсан сургалт- *Project Based Learning -PBL*:

Энэхүү сургалт нь суралцагчдад тодорхой хугацааны явцад нарийн төвөгтэй асуудал даалгавар, сорилт зэргийг судалж, шийдэл олох боломжийг олгодог. ТХБ-ын хүрээнд хичээл дээрх төслүүд нь бүс нутгийн болон дэлхийн тогтвортой байдлын асуудалд анхаарлаа төвлөрүүлж, оюутнуудад өгөгдсөн сэдвүүдийг гүнзгий судалж, шийдлээ англи хэл дээр танилцуулах боломжийг олгосноор хэлний чадамж эзэмших төдийгүй *хамтын ажиллагаа, бүтээлч байдал, иргэдийн оролцоо* ямар байх талаарх мэдлэг олгодог. Эдгээр мэдлэг, ур чадвар нь 21-р зууны дэлхийн иргэнд зайлшгүй байх чадвар юм.

Төслийн жишээ: “Тогтвортой сургууль, ухаалаг хотыг төлөвлөх” оюутнууд сургууль болон төрөлх хотоо байгальд ээлтэй болгох төлөвлөгөө боловсруулж, англи хэлээр танилцуулахдаа дэвшилтэт арга технологи ашиглан, хамтарч судалгаа хийн, бүтээлчээр даалгавар гүйцэтгэл хийдэг.

3. Кейс-тохиол судалгааны арга

Кейс судалгааны аргыг мөн түүнчлэн хичээлд хэрэгжүүлэх боломтой ба ТХЗ-ын сэдвүүдийн хүрээнд тодорхой хичээлүүдтэй холбогдох кэйс судлан шинжлэх арга юм. Энэ аргад ТХЗ-ыг англи хэлний хичээлд ашигласнаар тохиолдлын судалгаанууд нь сэдвүүдийг хэрхэн хичээлд тусгаж болохыг харуулдаг. Загвар кэйсээс дурдвал: “*Бүх нийтийн цэвэр ус*” - Унших, ярианы дунд шатны В1 хичээлийн даалгавар нь ТХЗ-6 буюу- *Цэвэр ус ба ариун цэврийн байгууламж*” хүрээнд хийж болох ба зорилго нь: Бодит ертөнцийн талаар уншиж ойлгох, чөлөөтэй ярих чадварыг хөгжүүлэх боломжтой. Кейс2: Тогтвортой хотыг төлөвлөх-Төсөлд суурилсан сургалтын хүрээнд SDG 11 – Тогтвортой хотууд ба нийгэмлэгүүд зорилгын хүрээнд хийх ажил нь *илтгэл тавих ур чадвар, ятгах чадвар бүхий эссээ бичих, хамтран ажиллах* зэргээр мэдлэг эзэмшиж болно. Мөн бүтээлч ур чадварыг хөгжүүлэх үүднээс тогтвортой хотын загвар зохион бүтээх, хотын тулгамдсан асуудлын талаар (жишээлбэл, хог хаягдлын менежмент, нийтийн тээвэр гэх мэт) судалгаа хийж, визуал загвар эсвэл постер бүтээж, загвараа англи хэлээр танилцуулах зэргээр creative ур чадвар суулгана. Үр дүнд нь “академик болон ятгах үг хэллэгийг бодитоор ашиглах”, “Тогтвортой байдлын талаар ярианд оролцох”, “Бүтээлч байдал, асуудлыг шийдвэрлэх чадвар” дээшилнэ.

Эдгээр сургалтын арга барилуудыг хичээлд хэрэгжүүлснээр ТХЗ-д нийцсэн арга зүй нь *хэл сурах* болон суралцагчдын хүрээлэн буй ертөнцтэйгээ *шүүмжлэлтэй харилцах чадварыг* хоёуланг нь сайжруулж байгааг харж байна. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг цөм болгосноор сурган хүмүүжүүлэгчид зөвхөн хэлний төдийгүй дэлхийн хэмжээний мэдлэг бүхий хариуцлагатай иргэнийг бий болгоход хувь нэмрээ оруулж байна.

Үр дүн

Тогтвортой хөгжлийн зорилтын 4 дүгээр зорилт болох “Чанартай боловсрол”-ын хүрээнд дэвшүүлсэн дэд зорилтууд нь англи хэлний хичээлийн агуулга, сургалтын арга зүйтэй уялдах боломжтой. Жишээ нь, боловсролын чанар, хүртээмжийг хангах (4.1) зорилт нь хэлний мэдлэгийн түвшинд *унших, бичих даалгавар, суралцагчийг дэмжих scaffolding* арга зүйгээр хэрэгжих боломжтой бол дээд боловсролд тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх (4.3) зорилтыг *академик англи хэл, судалгааны бичвэр, илтгэл бэлтгэх* сургалтаар дэмжих боломжтой. Мөн хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг хөгжүүлэх (4.4) зорилтыг *CV бичих, ажлын ярилцлагын симуляци, мэргэжлийн харилцааны даалгавруудаар*, дэлхийн иргэншил, хүний эрхийн боловсрол (4.7) нь *шүүмжлэлт сэтгэлгээнд суурилсан уншлага, мэтгэлцээн, төсөлд суурилсан сургалтаар үр дүнтэй* хэрэгжих боломжтой байна. Иймээс ТХЗ 4-ийн дэд зорилтуудыг англи

хэлний сургалтанд хэрэгжүүлэх нь хэлний чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ боловсролын чанар, хүртээмж, суралцагчийн чадамжийг цогцоор нь дээшлүүлэх бодит боломжийг бүрдүүлэх боломжтой гэж үнэлж байна.

Дүгнэлт

Дэлхийн иргэншсэн, мэдлэг ур чадвар бүхий иргэнийг төлөвшүүлэн, бэлтгэн гаргахад тухайн байгууллагын эрхэм зорилго хэдий ч ТХЗ-тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэлний заах арга зүйд нэвтрүүлэн, нэгтгэх нь хэлний боловсролд нэгэнтээ томоохон өөрчлөлт шинэчлэлтийг авчирч байгааг энэхүү ажлаараа онцлон дүгнэлээ. Суралцагсад ингэснээр хэлний мэдлэг + тогтвортой сэтгэлгээ гэсэн давхар ашигтай талыг эзэмшиж байгааг бид үнэлж байна. Цаашдаа энэхүү интеграцид илүү их судалгаа, шинэчлэл хийхийг уриалан гаргах нь бас зүйтэй гэж үзэж байна. Дэлхий нийт ээдрээтэй сорилтуудтай тулгараад байгаа өнөө үед англи хэл нь зөвхөн хэлний чадвар төдийгүй тогтвортой хөгжилд шаардлагатай шүүмжлэлтэй сэтгэлгээ, өрөвдөх сэтгэлтэй, иргэний хариуцлагыг хөгжүүлэхэд тохиромжтой орон зайг бий болгожээ. Энэхүү судалгааны ажил нь бодит харилцаа холбоо, суралцагчийн бие даасан байдал, бүтээлч байдал, соёл хоорондын ур чадварыг хөгжүүлэх замаар Тогтвортой хөгжлийн боловсролыг хэрхэн дэмжиж байгааг харуулсан бүтээл боллоо гэж дүгнэлтээ өндөрлөж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Barber, D. (2023, March 27). *The SDGs and English language teaching*. National Geographic Learning.
- Byram, M. (2008) *From foreign language education to education for intercultural citizenship*. Multilingual Matters. <https://doi.org/10.21832/9781847690807>
- Coyle, D., Hood, P., & Marsh, D. (2010). *CLIL: Content and language integrated learning*. Cambridge University Press. <https://doi.org/10.1017/9781009024549>
- Dörnyei, Z., & Ushioda, E. (2011). *Teaching and researching motivation*. Pearson Education. <https://doi.org/10.4324/9781351006743>
- Peachey, N. (2018). *Integrating global issues in the creative English language classroom*. British Council.
- UNESCO. (2017). *Education for Sustainable Development Goals: Learning objectives*. UNESCO Publishing.
- Widdowson, H. G (1978) *Content-based instruction: Content and language integrated learning (CLIL)*. Methods of Language Teaching.